

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн
зарцуулалт, үр дүн**



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ,
ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛААГҮЙ, СУМ
ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН
ЭРГЭН ТӨЛӨЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган</p> <p>Аудитын менежер Х.Женисбек</p> <p>Ахлах аудитор Х.Манаргүл М.Айнур</p> <p>Аудитор Б.Үүрийнтуяа Ж.Назгүл Х.Еркебулан</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайланг ҮАГазрын www.audit.mn вэб сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 95429524, 70423073 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 108, 107 тоот өрөө</p>	<p>Товчилсон үгийн тайлбар4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5-6</p> <p>Бүлэг 1. 1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч журамд заасан хувь хэмжээгээр хуваарилаагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • ОНХС-гийн хөрөнгийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна. 7 • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 235,5 сая төгрөгийг сумдын ОНХС-гийн 2016 оны үлдээглээс бүрдүүлсэн байна. 8-9 • ОНХС-гийн орлогын шилжүүлгийн 37,0 хувийг сумдын ОНХСанд хуваарилсан нь журамд заасан хувь хэмжээнд хүрээгүй байна. 9-12 <p>1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй байна. 12 • ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна. 12 • Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийг боловсруулахдаа иргэдээс саналыг авч, урьдчилсан саналын жагсаалт боловсруулж, хэлэлцүүлээгүй байна. 12-14 • Иргэдийн саналыг хууль журмын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна. 14-16 • Сумууд техник эдийн засгийн үндэслэлгүй, батлагдсан зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна. 16-17 • ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна. 17-18 • Сумууд бага өртөгтэй төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлжээ. 17-18 • Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан ажиллаагүй байна. 18-19 • Орон нутгийн хөгжлийн сангаас 40,6 сая төгрөгийг зориулалтын бус зарцуулжээ. 19-20 • ОНХС-гийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн 74,3 хувийг бүртгэл тайланд тусгасан байна. 20-23 <p>1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна.</p> <ul style="list-style-type: none"> • ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна. 23 • ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-гийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна. 23 • Дотоод аудитын алба ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна. 23 • ОНХС-гийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна. 23 • Сумын ОНХС-гийн хэрэгжилтийн явцын тайланг хүлээн авч хэлэлцсэн, биелэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна. 23-24 • Аймгийн Засаг дарга ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, ажиллуулсан байна. 24 • Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Шилэн дансны тухай” хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна. 24-25 • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, эрх зүйн орчныг сайжруулахад анхаарах асуудлууд байна. 25 • Санал асуулгын дүнгийн талаар 25-26
---	--

Дүгнэлт	27-28
Зөвлөмж:	29

Бүлэг 2. Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна 30
- Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаагаас сангийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй байна. 30
- Сангаас олгосон зээлийг хугацаанд эргэн төлүүлэх талаар хангалтгүй ажилласнаас нийт зээлийн үлдэгдлийн 74,5 хувь нь хугацаа хэтэрсэн байна. 31-32

2.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй байна.

- Сумууд төсөл шалгаруулахдаа журмын заалтыг баримталж ажиллаагүй байна. 32-34
- Өлгий сумын 2011-2016 онуудад 83 иргэн, хуулийн этгээдэд олгосон 424,5 сая төгрөгийн зээлийн гэрээ байхгүй байна. 34-35
- 2017 онд хэрэгжүүлсэн төслийн үр дүнд бий болсон ажлын байрыг баталгаажуулаагүй байна. 35-37

2.3. Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

- Сумын ИТХурал, Засаг дарга нар журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна. 37-39
- Сумууд сангийн жилийн эцсийн зээлийн үлдэгдлийг баталгаажуулаагүй ирсэн байна. 39-40
- Зээлийг хугацаандаа төлөөгүй, төслийг зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжийг шүүхэд шилжүүлж байгаа боловч үр дүн муутай байна. 40-41

2.4. Сангийн хөрөнгийг банкаар дамжиж олгохгүй байгаа нь зээлийн хүүгийн бодолт, зээлийн эргэн төлөлтийн хяналт хангалтгүй хэрэгжиж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. 41

Дүгнэлт	42
Зөвлөмж:	43

Бүлэг 3. Өмнөх онд ОНХСангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

- Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. 44
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 61,0 хувьтай хэрэгжсэн байна. 44-45

Дүгнэлт	46
---------------	----

Холбогдох байгууллагын санал	47
Саналд өгсөн тайлбар	48

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
СС	Сангийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЗЗНДТУТХ	Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хороодын Засаг дарга, ИНХ-ын шийдвэр, үйл ажиллагааг хамруулж, ОНХС-гийн 2017 оны хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн төсөл, арга, хэмжээ, түүний гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн СХС-гийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагналын явц, санхүүгийн болон ажлын тайлан, холбогдох бусад бичиг баримтуудыг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 1654,4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ОНХС-гийн дансанд 2017 оны эхэнд 430,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба улсын төсвөөс орлогын шилжүүлгээр 1546,4 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлогоос 124,0 сая төгрөгийн хөрөнгө төвлөрч, нийтдээ 1670,4 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнээс 842,7 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 827,7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилж, жилийн эцэст 76,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Аймаг, сумын ИТХ 2017 онд нийт 158 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 96,2 хувь буюу

152 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 1,3 хувь буюу 2 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 2,5 хувь буюу 4 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Хөдөлмөрийн сайдын багцад тусгагдсан Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2011-2014 онд нийт 3925,6 сая төгрөгийг Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрт олгосон байна.

Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн дээрх сангуудын хөрөнгийн зарцуулалтад хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үнэлсэн.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, холбогдох бусад хэлтэс, газруудын хариуцсан албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа авах, санхүүгийн баримт материалыг шалгах, санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг судлах, данс бүртгэл, анхан шатны баримттай тулган баталгаажуулах, ажиглалт хийх, биет тест хэрэгжүүлэх, иргэдээс санал асуулга авч дүн шинжилгээ хийх зэрэг горимуудыг ашигласан болно.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”.
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитын хугацаа, багийн бүрэлдэхүүн

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны зарцуулалтын байдалд 8 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд нийцлийн аудит хийлээ.

Аудитыг ахлах аудитор Х.Манаргүл ахалж, ахлах аудитор М.Айнур, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, аудитын тайланг бэлтгэв.

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаагүй байна.

Ерөнхий зүйл

Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитад аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, 13 сум, 1 тосгоны Орон нутгийн хөгжлийн сан болон бүх сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны үйл ажиллагааг бүрэн хамрууллаа.

Аудитын явцад аймгийн Орон нутгийн хөгжлийн сан болон 8 сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж шалган, 461 иргэнээс санал асуулга авч дүнг нэгтгэн тайланд тусгав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад 2014 оноос хойш жил бүр нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийгдэж байгаа бөгөөд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад нэгдсэн удирдамжаар анх удаагаа нийцлийн аудит хийгдсэн болно.

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч журамд заасан хувь хэмжээгээр хуваарилаагүй байна.

1.1.1. ОНХС-гийн хөрөнгийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын III дугаар хуралдааны 12 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийн нийт дүнг 2052,0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус IV хуралдааны 16 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг 1864,5 сая төгрөгөөр, 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит бус V хуралдааны 25 дугаар тогтоолоор 1872,5 сая төгрөгөөр тодотгож, анх баталсанаас 179,5 сая төгрөгөөр бууруулсан байна.


ОНХНС-гаас 1654,4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хүлээн авч, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 29,2 сая төгрөгийн, төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 8,0 сая төгрөгийн нийт 1691,6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт №1		/сая төгрөг/	
Санхүүжилтийн эх үүсвэр	Анх баталсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Өсөлт, бууралт
Орлого	2,052.0	1,872.40	179.60
ОНХНС-гаас хуваарилагдсан хөрөнгө	1,871.1	1,654.4	216.7
Аймгийн ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс	180.9	180.8	0.1
Ерөнхий дансны үлдэгдлээс		8.0	(8.0)
Үндсэн тэнцлийн ашиг		29.2	(29.2)
Сумуудын ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс			-
ОНХС-гийн нийт эх үүсвэр	2,052.0	1,872.4	179.6
Сумын ОНХС-д хуваарилсан	653.8	601.6	52.2
Аймгийн ОНХС-д хуваарилсан	955.1	827.7	127.4
ОНХС-гаас олгох суурь зарлага	443.1	443.1	-
Эцсийн үлдэгдэл	-	-	-

Эх сурвалж: аймгийн ИТХ-аас баталсан төсвийн төлөвлөгөө, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Алтай, Баяннуур, Булган, Буянт, Дэлүүн, Толбо, Цэнгэл сумууд ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс 235,5 сая төгрөгийг, аймгийн ОНХС-гийн үлдэгдлээс 180,8 сая төгрөгийг нэмж тодотгосон нь ОНХС-гийн эх үүсвэр өсөхөд нөлөөлсөн байна.

График №1



1.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 235,5 сая төгрөгийг сумдын ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс бүрдүүлсэн байна.

ОНХНСангаас тус аймгийн ОНХС-д олгох төлөвлөсөн орлогын шилжүүлэг 1654,4 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна.

Хүснэгт №2		/ сая төгрөг /	
Санхүүжилтийн эх үүсвэр	Анх баталсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	Өсөлт, бууралт
Орлого	1,872.4	2,107.90	-235.50
ОНХНС-гаас хуваарилагдсан хөрөнгө	1,654.4	1,654.4	-
Аймгийн ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс	180.8	180.8	-
Ерөнхий дансны үлдэгдлээс	8.0	8.0	-

Үндсэн тэнцлийн ашиг	29.2	29.2	-
Сумуудын ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс		235.5	(235.5)
ОНХС-гийн нийт эх үүсвэр	1,872.4	2,107.9	(235.5)
Сумын ОНХС-д хуваарилсан	601.6	837.1	(235.5)
Аймгийн ОНХС-д хуваарилсан	827.7	827.7	-
ОНХС-гаас олгох суурь зарлага	443.1	443.1	-
Эцсийн үлдэгдэл	-	-	-

Эх сурвалж: Сумдын ИТХ-аас баталсан төсвийн төлөвлөгөө, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөн Аймгийн ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс 180,8 сая төгрөг, төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 8,0 сая төгрөг, үндсэн тэнцлийн ашгаас 29,2 сая төгрөг, Сумуудын ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс 235,5 сая төгрөг тус тус бүрдүүлсэн байна.


1.1.3. ОНХС-гийн орлогын шилжүүлгийн 37,0 хувийг Сумдын ОНХСанд хуваарилсан нь журамд заасан хувь хэмжээнд хүрээгүй байна.

График №2



ОНХС-гаас тус аймагт олгосон орлогын шилжүүлгийн 763,6 сая төгрөгийг буюу 46,2 хувийг аймгийн Орон нутгийг хөгжүүлэх санд, 447,7 сая төгрөгийг буюу 27,4 хувийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд, 443,1 сая төгрөгийг буюу 26,4 хувийг ОНХС-гаас олгох суурь зарлагад хуваарилсан байна.

График №3



ОНХС-гаас олгох суурь зарлагыг хассан дүнгээс тооцож үзэхэд 37,0 хувийг сумуудын Орон нутгийн хөгжлийн санд, 63,0 хувийг аймгийн Орон нутгийн хөгжүүлэх санд хуваарилжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна”, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 9.2-т “Аймаг нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Мөн журмын 9.3-т “Итгэлцүүрт ашиглах сум, дүүргийн хөгжлийн индексийг аймаг, нийслэлийн Хөгжлийн бодлогын хэлтэс, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан сум, дүүргийн хөгжлийн индекс тооцох нийтлэг арга зүйн дагуу өөрийн аймаг, нийслэлийн хөгжлийн онцлог, тоон мэдээллийн боломжид нийцүүлэн тооцож, гаргана”, 9.4-т “Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Санхүү төрийн сангийн хэлтсээс аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэр тус бүрээр тооцсон холбогдох судалгааг аудитын явцад удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй болно. Аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтуудыг нэгтгэж үзэхэд ОНХС-гаас аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг дараах байдалтай байна.

Хүснэгт №3				/сая төгрөг/		
№	Сум	Хот тохижуулах газрын урсгал зардлын 50 хувь	Малын вакцинжуулалтын зардал	Олон улсын байгуулла-гын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал	Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруу-лан олгох дүн	Нийт хуваари-лагдах дүн
1	Алтай			27.5	22.1	49.6
2	Алтанцөгц				11.8	11.8
3	Баяннуур				21.1	21.1
4	Бугат				10.2	10.2
5	Булган				40.1	40.1
6	Буянт				14.2	14.2
7	Дэлүүн				35.9	35.9
8	Ногооннуур				29.4	29.4
9	Сагсай				16.5	16.5
10	Толбо			25.4	18.6	44.0
11	Улаанхус				28.7	28.7
12	Цэнгэл				36.5	36.5
13	Цагааннуур				7.9	7.9
14	Өлгий			55.1	46.7	101.8
	Дүн	0	0	108.0	339.7	447.7
15	Аймгийн ОНХС				763.6	763.6
	Дүн	0	0	-	763.6	763.6
16	ОНХС-гаас олгох суурь зарлага	100.7	342.4			443.1
	Нийт дүн	100.7	342.4	108.0	1103.3	1654.4
	Эзлэх хувь	6.1	20.7	6.5	66.7	100.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолын хавсралт

Аймгийн ОНХС-гаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.3-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жилд орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо орон нутгийн хөгжлийн индекс, тухайн сумын хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачлага зэрэг итгэлцүүрийг үндэслэн тогтооно” гэсний дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх ёстой.

Өөрөөр хэлбэл сумдын ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу Хүн амын тоог- харгалзах хувийг 25 хувиар, Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ- харгалзах хувийг 25 хувиар, Орон нутгийн татварын идэвх санаачлага-харгалзах хувийн жинг 25 хувиар хуваарилдаг журамтай байдаг.

Гэтэл 2017 онд ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө зөвхөн хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан тооцсон байна.

Аймгийн ОНХС-гийн дансанд 2017 оны эхэнд 430,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба улсын төсвөөс 1654,4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хүлээн авч, бусад орлогоос 37,2 сая төгрөгийн орлого төвлөрч, нийтдээ 1691,6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 2045,6 сая төгрөгийг төсөл хөтөлбөр, бусад зардалд зарцуулан оны эцэст 76,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг 9 үзүүлэлтээр үнэлж, ОНХС-гийн хуваарилсан хөрөнгийн тодорхой хувийг урамшуулах замаар олгож байгаа бөгөөд 2017 онд тус аймгийн Алтай, Толбо, Өлгий сумдад 107,9 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

ОНХС-гийн хөрөнгийн хуваарилалтыг аймаг, сум бүрээр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4		/ сая төгрөг /			
№	Сумдын нэр	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Санхүүжүүлсэн дүн	Зөрүү мөнгөн дүнгээр
1	Алтай	55.9	60.9	60.9	-
2	Алтанцөгц	20.1	17.8	17.8	-
3	Баяннуур	26.5	29.1	29.1	-
4	Бугат	12.1	18.4	18.4	-
5	Булган	58.3	52.1	52.1	-
6	Буянт	44.3	22.1	22.1	-
7	Дэлүүн	54.9	47.9	47.9	-
8	Ногооннуур	55.5	42.6	42.6	-
9	Сагсай	54.5	26.8	26.8	-
10	Толбо	80.2	52.0	52.0	-
11	Улаанхус	59.3	42.4	42.4	-
12	Цэнгэл	65.6	53.4	53.4	-
13	Цагааннуур	9.5	14.2	14.2	-
14	Өлгий	57.1	121.9	121.9	-
	Дүн	653.8	601.6	601.6	-
15	Аймгийн ОНХСан	955.1	827.5	827,5	0
	Дүн	1,608.9	1,429.1	1,429.1	

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолын хавсралт, аймгийн СТСХэлтэсээс

2017 онд аймаг, сумдад олгох орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХурлаас баталсан ОНХС-гийн шилжүүлгийг хуваарийн дагуу бүрэн шилжүүлж, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг мөрдөж ажилласан байна.

1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.

1.2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй байна.

1.2.1.1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын”-ын 2.2-т “ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь УИХурал, Засгийн газрын болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги түүнтэй холбоотой бусад бичиг баримттай уялдсан байна”, 4.1-д “ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байна” гэсний дагуу 13 сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажлуудын 80 орчим хувь нь Сумуудын 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын 2017-2020 оны мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсээс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл, арга хэмжээг төсөл, хөтөлбөр тус бүрээр гаргаж ирүүлсэн тайланг тулгаж үзэхэд аймгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан байна.

1.2.1.2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийг боловсруулахдаа иргэдээс саналыг авч, урьдчилсан саналын жагсаалт боловсруулж, хэлэлцүүлээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар иргэдээс санал авах ажлыг 6 сум иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан саналын хуудсаар санал авсан байна.

Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.1.а-д “баг, хорооны иргэдээс санал асуулгыг авахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна”, 12.2.2-т “баг, хорооны Засаг дарга холбогдох маягтын дагуу тухайн баг хорооны иргэдийн ирүүлсэн саналыг багийн иргэдийн нийтийн хуралд хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ”, 12.2-д “хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх”, 12.2.2.б-д “хэдэн хүн ашиг хүртэх”, 12.2.2.в-д сум, дүүргийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх”, 12.2.2.г-д “төслийн нийт өртөг зэргийг тусгасан байна”, 12.2.4-т “баг, хорооны

Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ” гэсэн заалтуудыг Алтай, Алтанцөгц, Буянт, Дэлүүн, Сагсай Цэнгэл сумууд хэрэгжүүлж иргэдээс санал авч урьдчилсан саналын жагсаалт боловсруулж хэлэлцүүлэн журмын дагуу ажилласан байна.

Баяннуур, Бугат, Булган, Толбо, Ногооннуур, Өлгий сумууд дээрх заалтуудыг зөрчиж иргэдээс санал аваагүй, саналын жагсаалт боловсруулж хэлэлцүүлээгүй байна. Буянт, Цагааннуур тосгон, Улаанхус сумууд 2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй, Улаанхус сум 2017 оны ОНХС-гийн хөрөнгийг олон нийтийн оролцооноос гаргах дутуу санхүүжилтэд олгосон байна.

2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх ажлын талаар иргэдээс санал авах ажлыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.2-т “Баг хорооны иргэдийн нийтийн хурлын дарга ирэх онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх санал хураах хурлыг жил бүрийн 5 дугаар сард багтаан зохион байгуулна” гэж заасан боловч сумууд санал авах ажлыг 6-12 дугаар сард зохион байгуулж, журамд заасан хугацааг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 827,5 сая төгрөгийн 33 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг дээрх журмын 6.3.4-д “орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх” гэж заасан шаардлагыг хангасны дагуу төлөвлөгөөний жагсаалт боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлж, аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Эдгээр хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төслийг боловсруулахдаа иргэдийн дунд нээлттэй санал аваагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх дарааллыг ач холбогдлоор нь эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулаагүй, тулгамдаж буй арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг боловсруулж орон нутгийн радиогоор зар өгч, аймгийн ЗДТГ-ын цахим хуудаст байршуулан санал авах ажлыг зохион байгуулаагүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийг боловсруулахдаа Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар бүлгийн 12 хэсгийн 12.1.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна”, 12.1.2-т “иргэд, олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэт технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна”,

12.1.3-т “аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулна”, 12.1.4-д “аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах асуудлын урьдчилсан жагсаалтыг олон нийтээр хэлэлцүүлж, баталгаажуулах үйл

ажиллагааг сум, дүүргийн нэгдсэн жагсаалт боловсруулах үйл ажиллагаатай хамтад нь явуулж болно”,

12.1.5-т “аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг ханган тухайн шатны ИТХуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2.1.3. Иргэдийн саналыг хууль журмын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна.

Сумуудаас Алтай, Буянт, Дэлүүн, Сагсай сум Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.5-т “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад сумууд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4-т “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”,

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.1-д “Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах”, 6.3.5-д “иргэдийн оролцоог хангасан байх”, 12 дугаар зүйлийн 12.2.5-т “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална”,

12.2.5.а-д “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар баг, хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэж, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг бэлтгэнэ”, 12.2.5.б-д “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулна”,

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2-т “Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Баяннуур сум багийн нийтийн хурлыг зохих журмын дагуу зохион байгуулж, саналыг эрэмбэлээгүй, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолоогүй, сумын ЗДТГазар багуудаас ирүүлсэн саналуудыг нэгтгэж саналын дарааллаар нэгдсэн жагсаалт бэлтгээгүй, арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах, ажлын хэсэг томилоогүй байна.

Алтанцөгц, Булган, Цэнгэл, Өлгий сумын удирдлага иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн саналыг эрэмбэлж оруулаагүй, сумын ЗДТГ-аас гаргасан саналыг ИТХ-д шууд оруулж батлуулжээ.

Бугат, Толбо, Ногооннуур, Өлгий сум, Цагааннуур тосгон иргэдийн саналыг аваагүй, иргэдийн нийтийн хурал хийгээгүй, сумын ЗДТГ-ын саналаар эрэмбэд оруулж, сумын ИТХ-ын хуралдаанаар хөрөнгө баталж, хэрэгжүүлжээ. Мөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөлд иргэдийн саналыг аваагүй байна

Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Ногооннуур, Цэнгэл, Толбо, Өлгий сум, Цагааннуур тосгон, аймгийн ОНХС-аас иргэдийн саналаар дэмжигдээгүй 77 төсөл, арга хэмжээнд 1075,4 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумын хэмжээнд 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд иргэдээс авсан саналыг 2016 оны хүн, ам өрхийн тоонд харьцуулсан байдлыг хүснэгтээр харуулахад:

<i>Хүснэгт №5</i>				<i>/сая төгрөг/</i>	
Аудитад хамрагдсан сум	Багийн тоо	Өрхийн тоо /2017 он/	Хүн амын тоо/18 - аас дээш настай /	Санал авсан иргэний тоо	Санал авсан хувь
Алтай	5	1122	2351	869	37.0
Алтанцөгц	4	749	1578	535	33.9
Баяннуур	5	1151	2620	59	2.3
Бугат	4	972	2069	0	-
Булган	7	1183	2890	468	16.2
Буянт	4	768	1590	634	39.9
Дэлүүн	10	1594	3852	658	17.1
Ногооннуур	9	1951	4249	0	-
Сагсай	6	1250	2716	480	17.7
Толбо	6	970	2242	0	-
Улаанхус	8	1819	4418	0	-
Цэнгэл	9	2001	4805	2272	47.3
Өлгий	13	7792	19909	0	-
Аймаг	0	0	0	0	
Дүн		23322	55289	5975	25,6

Эх сурвалж: Аймгийн Статистикийн хэлтсийн вэб сайт, сумдын холбогдох баримтаас

ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөлд санал авах үйл ажиллагаанд аймгийн дүнгээр 5975 иргэн оролцож, сумдын нийт өрхийн 25,6 хувийг хамруулсан байна.

Алтай, Алтанцөгц, Булган, Дэлүүн, Сагсай, Цэнгэл сумууд “багт 4 өрх тутмаас нэг хүн” гэсэн заалтыг мөрдөж ажилласан байна.

Харин Бугат, Баяннуур, Ногооннуур, Толбо, Өлгий сум ЗЗНДНТУТХуулийн 23 дугаар зүйлийн 10-д “Баг, хорооны хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцох бөгөөд тухайн хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Иргэдээс авсан санал асуулгын дүнг нэгтгэж үзэхэд:

- “Таны баг, хорооны Засаг дарга 2017 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг

- иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?* гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 59,4 хувь буюу 180 иргэн “тийм” гэсэн хариултыг,
- “*Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?*” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 55,8 хувь буюу 169 иргэн “тийм” гэсэн хариултыг,
 - “*Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?*” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 54,5 хувь буюу 165 иргэн “тийм” гэсэн хариултыг,
 - “*Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?*” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 52,1 хувь буюу 158 иргэн “тийм” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд иргэдийн санал авах ажлыг зохих журмаар хэрэгжүүлдэггүй, ИНХ-д оролцох иргэдийн оролцоо бага, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.1 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

1.2.1.4. Сумууд техник эдийн засгийн үндэслэлгүй, батлагдсан зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

2017 онд аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор 166 төсөл, арга хэмжээг 1577,9 сая төгрөгийн төсөвт өртгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 140 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, 133 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 5 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 814,5 сая төгрөгийн өртөг бүхий 31 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж, зураг төсөв нь батлагдаж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн байна.

Алтанцөгц, Баяннуур, Булган, Ногооннуур, Толбо сумууд зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй 21 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7-д “Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний холбогдох зөвшөөрөл, ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилж батлуулах, ТЭЗҮ, зураг төсөвгүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг зөрчлийг дахин гаргахгүй байх талаар 5 сумын Засаг даргад албан шаардлага өгөв.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна.

1.2.2.1. Сумууд бага өртөгтэй төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлжээ.

ОНХС-гаас хэрэгжүүлсэн 109 төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд 62 аж ахуйн нэгж, компани, 47 иргэдийн бүлэг оролцож худалдан авах үйл ажиллагааг хангасан байна. Тухайлбал:

- Аймгийн ОНХСан болон Алтай сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бүгд 9 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар
- Аймаг, Өлгий сумын ОНХСан, Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Дэлүүн, Толбо, Ногооннуур, Сагсай, Цэнгэл сумууд бүгд бага өртөгтэй 100 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулах замаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Харин Буянт, Улаанхус сум, Цагааннуур тосгон 2017 онд ОНХСангийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ОНХСангийн 21 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар, 87 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сумуудын ЗДТГазраас шууд гэрээгээр худалдан авахаар зохион байгуулсан байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 2017 онд Өлгий сумын хаягжуулалт, Өлгий сумын 13-р багт цахилгаан татах, Өлгий сумын үерээс хамгаалах далангийн зураг төсөв, Бөхөн уулын бэлд өрөмдмөл гүний худаг гаргах, Нэгдсэн эмнэлгийн шүдний бор, ариутгалын автоклав, Төрөх тасагт эх нярайн цомог, угаалгын машин, Цагдаагийн газрын камерын арчилгаа, хамгаалалт, МХГазрын Цагааннуур боомтын тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг төслүүдийг хэрэгжүүлжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу захиалагчаас тендер шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-3 сертификаттай 1-2 хүнийг оруулж, 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажилласан байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, аймгийн ЗДТГазарт гэрээ байгуулах тухай зөвлөмж хүргүүлсэн байна.

ЗДТГазар ажил гүйцэтгүүлэх гэрээг Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт бичигт заасны дагуу тендер шалгаруулалтын гэрээний маягтаар зохих журмын дагуу байгуулжээ.

Булган сумын “Урт хэцүү”-д хийгдсэн гүүрний засварын 25,0 сая төгрөгийн ажлыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох

бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Цэнгэл сумын 3 дугаар багийн далан босгох ажлын санхүүжилтээс 7.3 сая төгрөг, 9-р багийн далан босгох ажлын санхүүжилтээс 8.9 сая төгрөг, Бейтсайн замын засварын санхүүжилтээс 1.0 сая төгрөгийг, нийт 17.2 сая төгрөгийг гэрээ байгуулсан гүйцэтгэгч иргэн, ААН-ийн дансанд биш “Ник” ХХК болон “Ой” хоршооны дансанд шатахууны үнэ гэж шилжүүлсэн байна.

Өлгий сум Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн саналын жагсаалтад ороогүй, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаагүй 1-13-р багуудын эзэнгүй хог цэвэрлэх” 13.0 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн зэрэг нийдтээ 5 төсөл арга хэмжээнд 55,2 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрснийг арилгах талаар албан шаардлага өгөв.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллах шаардлагатай байна.

1.2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримталж ажиллаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2.2, 45.6-д заасны дагуу аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга захиалагчийн үүргийг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХСангаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтыг ажлын нарийн төвөгтэй байдлыг харгалзан Барилга захиалагчийн албанд хуваарилан өгч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, хавсралтаар хариуцуулан хяналтын ажлыг хийлгэж 5,7 сая төгрөгийн зардлыг шилжүүлсэн байна.

Барилга захиалагчийн алба төсөл, арга хэмжээний талбайд хийж гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, хугацаа, чанар, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн актад захиалагчийг бүрэн төлөөлж хяналт тавьж, гарын үсэг зурж, Хөгжлийн бодлогын хэлтсээс хяналтын хуудсаар давхар хяналт тавьж, гэрээний дагуу санхүүжилтийг олгосон байна.

Барилга захиалагчийн албанаас 2017 онд ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн 31 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, барилга угсралтын ажил, төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан үед орон нутгийн холбогдох байгууллага, Аймгийн ЗДТГазрын холбогдох мэргэжилтнүүд, иргэдийн төлөөллийг оролцуулсан комисс ашиглалтад хүлээн авч, холбогдох бичиг баримт материалыг бүрдүүлсэн байна.

Аудитаар ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гэрээний заалтын дагуу олгоогүй дараах зөрчил дутагдал илэрлээ.Үүнд:

-Баяннуур сум ОНХСангаас сумын ИТХурлын төлөөлөгч Х.Лена, иргэн Ж.Унат нарт өвс тэжээлийн нөөц бэлтгэх төсөл арга хэмжээнд 4.5 сая төгрөг олгож, ЗДТГ-ын даргын 2018 оны 12-р сарын 25-ний өдрийн 36 дугаар тушаалаар багуудад хөнгөлөлттэй үнээр хуваарилсан гэх боловч өвс тэжээлийн нөөц бэлтгэсэн, түүнийг хүлээн авсан, багуудад тараасныг нотлох анхан шатны баримт, материалгүй, гэрээний 3,2 дахь заалтыг зөрчсөн тул акт тогтоов.

-Баяннуур сум сумын төвд хашаа хайс барих, гудамжны гэрэлтүүлэг, тээврийн хэрэгслийн зогсоол, явган зам засах, нийтийн бие засах газар шинээр барих ажлын гүйцэтгэгч Цул-Улаан ХХК-д 0,3 сая төгрөг, Цагаан арал багт мал угаах ванн барих ажлын гүйцэтгэгч иргэн Б.Хуанганд 0,4 сая төгрөг, Булган сум Ёлтын бага сургуулийн хөгжлийн танхим, засварын ажлыг гүйцэтгэсэн “Ахбаты Ители” ХХК-д 0,2 сая төгрөгийг гэрээний дүнгээс илүү олгосныг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.

-Баяннуур сум сумын төв болон Цэцэгт багт “Хүүхдийн тоглоомын талбай барих”, сумын төвд хашаа хайс барих, гудамжны гэрэлтүүлэг, тээврийн хэрэгслийн зогсоол, явган зам засах, нийтийн бие засах газар шинээр барих, зэрэг 6 төсөл хөтөлбөр дутуу буюу чанаргүй хийгдсэн, гэрээний хугацаа хэтэрсэн, хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавиагүй, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримталж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдал илэрснийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”, 2016 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитын дүнгээр дээрх **5,3** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, **31,0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн.

1.2.2.3. Орон нутгийн хөгжлийн сангаас 40,6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулжээ.

Аймгийн ОНХСан, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Ногооннуур, Толбо, Цэнгэл, Өлгий сум, Цагааннуур тосгон орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлэгдээгүй 77 төсөл, арга хэмжээнд 1075,4 сая төгрөгийн хөрөнгийг ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийн 60.3.4, 63.1, 63.2, 63.3, 63.4, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох сумын Засаг дарга, аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга нарт албан шаардлага өгөгдлөө.

Аудитаар ОНХСангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Өлгий сумын ОНХСангаас 2017 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 50 тоот төлбөрийн хүсэлтээр 1-р гарын үсгийг Өлгий сумын Засаг дарга, 2-р гарын үсгийг төрийн сангийн төлөөлөгч нар зурж сумын ЗДТГ-ын Үйлдвэрчний хорооны Төрийн банкин дахь дансанд 11,5 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр хууль бусаар шилжүүлсэн байна.
- Үйлдвэрчний хорооны данснаас Өлгий сумын гэрэлтүүлгийн ажлын санхүүжилтэд 5,9 сая төгрөгийг олгожээ. Тухайн үед төрийн сангийн төлөөлөгчөөр ажиллаж байсан Х.Ыдырыш нь 2018 онд нас барсан бөгөөд үлдсэн **5,6** сая төгрөгийг юунд зарцуулсан нь тодорхойгүй, баримтгүй байна.
- Дэлүүн, Бугат сумууд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулан баталж Улаан загалмайн ажилтны урамшуулал, иргэний танхимын ажилтаны цалинд бүгд **6,9** сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- Ногооннуур сум Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тээвэр шатахууны зардалд 5,0 сая төгрөгийн шатахууныг зориулалт бусаар анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.
- Алтанцөгц сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд урамшуулалд 0,5 сая төгрөг олгосон байна. Орон нутгийн хөгжлийн сангаас зориулалт бус зарцуулсан **18,0** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Мөн ОНХСангийн хөрөнгөнөөс Сагсай сум 5.1 сая төгрөгийг Гамшгийн сан байгуулсан, зураг төсөв батлагдаагүй, мэргэжлийн байгууллагаас техникийн нөхцөл олгогдоогүй байхад Сургуулийн дотуур байр, гал тогооны цахилгааны засварт 6.2 сая төгрөгийг зарцуулсан, Цэнгэл сум гамшгаас хамгаалах сан байгуулах төсөл арга хэмжээнд 11.3 сая төгрөг төлөвлөж, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан зэрэг нийтдээ **22,6** сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчилд дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдөв.

1.2.2.4. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн 74,3 хувийг бүртгэл тайланд тусгасан байна.

ОНХС-ийн санхүүжилтээр 2017 онд нийт 109 төсөл, арга хэмжээ, хөтөлбөр хэрэгжсэнээс 81 төсөл арга хэмжээний 644,1 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд комиссын актаар хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь ОНХСангаас зарцуулсан нийт хөрөнгийн 74,3 хувийг эзэлж байна.

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 21 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, комиссын актаар хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.



Өлгий сумын хаягжуулалт



Аймгийн Нэгдсэн эмнэлгийн шүдний бор машин, ариутгалын автоклав



Нэгдсэн эмнэлгийг төрөх тасагт нярайн цомог, угаалгын машин



Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын шинжилгээний анализатор



Хүүхдийн тасагт дуслын шахуурга



Өлгий сумын ЗДТГазрын засвар

Өлгий сумын 3-р багийн гэрэлтүүлэг



Ногооннуур сумын гудамжны гэрэлтүүлэг

Ногооннуур сумын БДСургууль тоног төхөөрөмж

ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг тухайн байгууллагууд данс бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан эсэхийг тулгаж үзэхэд Ногооннуур сумын ЗДТГазар аймгийн ОНХСангийн хөрөнгөөр Улаан чулуут багт тавьсан 4,0 сая төгрөгийн трансформаторыг орлого аваагүй байна.

Булган сумын баяр наадмын зардалд зарцуулсан баримтуудыг бүрдүүлж, санхүүгийн баримт материалд хавсаргаагүй зэрэг 3,5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.3-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6-д “ОНХС-ийн хөрөнгөөр

хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна.

1.3.1. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

1.3.1.1. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт санхүүжилт гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана”, 9.4-т “Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХСангаас хэрэгжсэн хөтөлбөр төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ” гэж заасан байна.

Улаанхус, Дэлүүн сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан байна.

Баяннуур, Булган, Бугат, Толбо сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй, бусад сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо 1-2 удаа хяналт тавьж ажилласан нь хангалтгүй байна.

Аудитаар авсан санал асуулгаар иргэдээс “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?” гэсэн асуултад 46,2 хувь нь буюу 140 иргэн “тийм”, 53,8 хувь нь буюу 163 иргэн “үгүй” гэж хариулсан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх заалтад байгаа иргэдийн хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

1.3.1.2. Дотоод аудитын алба ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймаг, сумын ОНХС-гийн 2017 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

1.3.2. ОНХС-ийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна.

1.3.2.1. Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланг хүлээн авч хэлэлцэж, биелэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-д заасны дагуу сумын Засаг даргын тамгын газраас ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг 2017 оны 7 дугаар арын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 1-ний дотор аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн байдлыг шалгаж үзэхэд:

Хагас жилийн тайланг Өлгий, Алтай, Бугат, Булган, Толбо, Сагсай, Улаанхус, Дэлүүн сум, Цагааннуур тосгон ирүүлсэн, Алтанцөгц, Баяннуур, Буянт, Ногооннуур, Цэнгэл сум ирүүлээгүй байна.

Жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг Алтай, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Толбо, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум, Цагааннуур тосгон ирүүлсэн байна.

Засаг даргын захирамжаар сумуудын ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн үр дүнгийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг томилж ажиллуулсан байна.

Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдлыг сумуудын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй уялдуулж дүн шинжилгээг хийж, дүнг аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулагдсан сумын удирдах ажилтны зөвлөгөөн дээр танилцуулж, зөвлөмж, чиглэл өгч, аймгийн ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн тайланг Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

1.3.2.2. Аймгийн Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, ажиллуулсан байна.

2017 онд Орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэж, тайлагнах ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргаар ахлуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Төр, захиргаа, удирдлагын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, танилцуулгыг сонин, хэвлэмэл материал болгон гаргаж, олон нийтийн хэвлэл мэдээллээр түгээж ажилласан байна.

Мөн Сангийн яамнаас хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан “Аймгийн чадавх бэхжүүлэх баг”-ийг аймгийн Засаг даргын 2017 оны А/231 дүгээр захирамжаар байгуулжээ.

Тухайн баг сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн явцад сургалт зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэх, сурталчлах ажлуудыг зохион байгуулж, төслийн багт дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй ба сонгосон сумуудаар явж ажиллажээ. Алтай, Буянт, Толбо, Дэлүүн, Булган сумуудын ОНХСангийн 2016, 2017 оны гүйцэтгэлийн үнэлгээг газар дээр нь танилцуулж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь биечлэн үзэж, зөвлөмж, чиглэл өгч ажилласан байна.

1.3.2.3. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Шилэн дансны тухай” хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна.

Аймаг, сумын ЗДТГазраас Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын 5.1-д заасны дагуу 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, ажлуудыг нэр

төрөл, өртөг, зардлын дүнгээр Сангийн яамны “Pmmis.mof. gov.mn”, аймгийн “bayan-ulgii.gov.mn” вэб сайтад байршуулсан байна.

Харин Булган, Баяннуур, Ногооннуур сум нь ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний талаарх 2017 оны мэдээллийг Шилэн дансны Вэб сайтад байршуулаагүй байна.

1.4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, эрх зүйн орчныг сайжруулахад анхаарах асуудлууд байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан хууль журмын нийцлийг судалж үзэхэд бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа зүйл ажиглагдаагүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний төсөлд багийн иргэдээс авсан санал нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй бүрэн уялдаагүй, сумын ЗДТГ-аас иргэдийн дунд санал явуулахдаа сумын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, тухайн онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн жагсаалтыг урьдчилан танилцуулах ажил хангалтгүй хийгдэж ирсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр орон нутагт тодорхой ажлууд хийгдэж байгаа боловч үр өгөөжтэй томоохон бүтээн байгуулалтад чиглэгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх асуудал дутагдалтай байна.

Цаашид Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй бүрэн уялдуулах, иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан үр өгөөжтэй томоохон төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд чиглүүлэх, үүнийг холбогдох хууль, заавар, журмуудад тусгах шаардлагатай байна.

Санал асуулгын дүнгийн талаар:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ? гэсэн асуултанд 201 иргэн буюу санал асуулгад оролцсон иргэдийн 66,3 хувь нь “хангалттай”, 102 иргэн буюу 33,7 хувь нь “хангалтгүй” гэж хариулжээ.

2. Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авсан бэ? гэсэн асуултанд 32 хувь буюу 97 иргэн Засаг дарга, хороодын хэсгийн ахлагчаас, 24,1 хувь буюу 73 иргэн Орон нутгийн мэдээллийн самбар, радио, телевизээс, 13,2 хувь буюу 40 иргэн Иргэний танхимын ажилтнаас, 30,7 хувь буюу 93 иргэн Нутгийн иргэдээс гэсэн харилт өгчээ.

3. Та Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн үү? гэсэн асуулгад санал асуултанд оролцсон иргэдийн 54,1 хувь буюу 164 иргэн “тийм”, 45,9 хувь буюу 139 иргэн “үгүй” гэж хариулсан байна.

4. Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ? гэсэн асуултанд 46,9 хувь нь буюу 142

иргэн “тийм”, 27,7 хувь нь буюу 84 иргэн “үгүй”, 25,4 хувь буюу “мэдэхгүй байна” гэж хариулсан байна.

Ихэнх хувь үгүй, мэдэхгүй гэж хариулсан нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр талаарх ойлголт дутмаг, хийгдэж буй төсөл арга хэмжээ олон нийтэд хүртээмжгүй байгааг харуулж байна.

Орон нутгийн хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар нийтдээ 1300,6 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 23,8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1276,8 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүллээ. 11 сумын ОНХСанд 449,3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, Аймгийн ОНХСанд 827,5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага тус тус өгөв.

Мөн Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад Орон нутгийн хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгсөн болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилаагүй байна.

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн боловч журамд заасан хувь хэмжээгээр хуваарилаагүй байна.

- 1.1.1. ОНХС-гийн хөрөнгийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.
- 1.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 235,5 сая төгрөгийг сумдын ОНХС-гийн 2016 оны үлдэгдлээс бүрдүүлсэн байна.
- 1.1.3. ОНХС-гийн орлогын шилжүүлгийн 37,0 хувийг Сумуудын ОНХСанд хуваарилсан нь журамд заасан хувь хэмжээнд хүрээгүй байна.

1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.

1.2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримтлаагүй байна.

- 1.2.1.1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.
- 1.2.1.2. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийг боловсруулахдаа иргэдээс саналыг авч, урьдчилсан саналын жагсаалт боловсруулж, хэлэлцүүлээгүй байна.
- 1.2.1.3. Иргэдийн саналыг хууль журмын дагуу эрэмбэлж, төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна.
- 1.2.1.4. Сумууд техник эдийн засгийн үндэслэлгүй, батлагдсан зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллаагүй байна.

- 1.2.2.1. Сумууд бага өртөгтэй төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлжээ.
- 1.2.2.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримталж ажиллаагүй байна.
- 1.2.2.3. Орон нутгийн хөгжлийн сангаас 41,1 сая төгрөгийг зориулалтын бус зарцуулжээ.

1.2.2.4. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн 74,3 хувийг бүртгэл тайланд тусгасан байна.

1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна.

1.3.1. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

1.3.1.1. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

1.3.1.2. Дотоод аудитын алба ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

1.3.2. ОНХС-ийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан байна.

1.3.2.1. Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланг хүлээн авч хэлэлцэж, биелэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.3.2.2. Аймгийн Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, ажиллуулсан байна.

1.3.2.3. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Шилэн дансны тухай” хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ербол-д:

1. ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-анд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөж, хуваарилах.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Болат-д:

1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг баримталж ажиллах.

Бүлэг 2

Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2. Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг баталж, Засгийн газрын 2016 онд 153 дугаар тогтоолоор журмыг шинэчлэн баталсан байна.

Журамд Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар тусгасан байна.

2.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

2.1.1. Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаагаас сангийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй байна.

Сум хөгжүүлэх санд улсын төсвөөс 2011-2014 онуудад нийтдээ 3925,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба энэхүү хөрөнгийг жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, өрхийн жижиг бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд бага хүүтэй хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож эргэлтэд оруулсан бөгөөд 2014 оноос хойш улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна.

Тус аймгийн 14 сумын Сум хөгжүүлэх сангийн дансанд 2017 оны эхэнд 44.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба 2017 онд 594.6 сая төгрөгийн орлого орсон байна. Үүний 554.0 сая төгрөг нь үндсэн зээлийн эргэн төлөлтөөс, 40.6 сая төгрөг нь хүүгийн орлогоос орсон байна.

2017 онд зээл, зээлийн хүүгээс эргэн төлүүлсэн 594.6 сая төгрөг нь зээлийн гэрээний дагуу эргэн төлөгдөх ёстой нийт төлбөрийн 18,5 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Сумуудын ИТХ-аас Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлогыг зээлийн эргэн төлөлтөөс нийт 1435,2 сая төгрөг бүрдүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 594,6 сая төгрөг орж төлөвлөгөө 58,6 хувь буюу 840,6 сая төгрөгөөр биелэгдээгүй тасарсан байна.

Сумуудын сум хөгжүүлэх сангаас олгосон зээл гэрээний хугацаанд төлөгдөхгүй, хугацаа хэтэрснээс сангийн төлөвлөсөн орлого бүрдэхгүй, эргэлт

удааширсан байна. Энэ нь зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт сул байгаатай холбоотой.

Сумуудын сум хөгжүүлэх санд 2017 онд хандив, тусламжийн орлого ороогүй байна

2.1.2. Сангаас олгосон зээлийг хугацаанд эргэн төлүүлэх талаар хангалтгүй ажилласнаас нийт зээлийн үлдэгдлийн 74,5 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

Сумуудын дүнгээр 2017 оны эхэнд 1158 төсөлд олгосон 4028.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 1076 төсөлд олгосон 3001.0 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөрийн хугацаа хэтэрсэн байна.

Сумын Засаг дарга нар Сум хөгжүүлэх сангийн зээлийг төлүүлэх талаар санаачлага гаргаж тодорхой арга хэмжээ авч ажилладаггүй, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд журмыг мөрдөхгүй, зээл төлүүлэх талаар шаардлага тавьж ажиллаагүй, хариуцсан албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж ирсэн байна.

Нөгөө талаар зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжүүд журмын 4.7-д "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" гэсэн заалтын дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Журмын 1.7-д "Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана" гэсэн заалтыг сумууд мөрдөж ажиллаагүй, хугацаа хэтэрсэн зээлд гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй байна.

Хүснэгт №6

/сая төгрөг/

№	Сумын нэр	Зээл, зээлийн хүүгийн эхний үлдэгдэл		Үүнээс								Зээл, зээлийн хүүгийн эцсийн үлдэгдэл	
				Барьцаа хөрөнгөгүй зээлийн		Гэрээ байгуулаагүй зээлийн		Зориулалтын дагуу ашиглаагүй зээлийн		Хугацаа хэтэрсэн зээлийн			
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1	Алтай	61	223.0	-	-	-	-	-	-	98	134.7	98	239.6
2	Алтанцөгц	53	219.5	50	147.0	-	-	3	12.0	57	161.0	57	195.0
3	Баяннуур	96	280.8	20	68.8	-	-	42	132.9	104	253.4	104	343.0
4	Бугат	36	180.0	-	-	-	-	-	-	36	125.9	87	203.9
5	Булган	113	184.6	-	-	-	-	-	-	86	127.8	113	227.2
6	Буянт	42	223.4	34	148.5	-	-	27	123.3	14	31.9	32	130.4
7	Дэлүүн	69	278.4	-	-	-	-	-	-	57	124.4	78	273.9
8	Ногооннуур	62	265.2	51	162.3	11	95.0	21	81.4	59	229.2	62	257.2
9	Сагсай	43	297.1	-	-	-	-	-	-	29	147.7	29	243.1
10	Толбо	47	238.3	34	148.5	-	-	27	123.3	31	158.2	47	224.9
11	Улаанхус	95	336.6	4	20.7	-	-	60	140.0	104	338.1	104	388.1
12	Цэнгэл	102	336.3	31	79.8	-	-	75	167.0	98	258.4	91	287.7
13	Өлгий	335	961.1	24	115.4	8	52.3	-	-	243	908.8	335	965.2
14	Цагааннуур тосгонд	4	4.0	3	1.5	-	-	-	-	3	1.5	3	1.5
	Нийт дүн	1158	4028.3	251	892.5	19	147.3	255	779.9	1019	3,001.0	1,240	3980.7

Эх сурвалж: Сумуудын СХСангийн зээлийн талаарх нэгдсэн судалгаа

Зээлийн эргэн төлөлт Өлгий, Ногооннуур, Сагсай, Толбо сумд 2,6-5,7 хувьтай, Бугат, Алтанцөгц, Дэлүүн, Улаанхус сумд 10,5-18,0 хувьтай, Булган, Баяннуур, Цэнгэл сумд 20,2-23,3 хувьтай, Алтай сумд 37,6 хувьтай, Буянт сумд 44,7 хувьтай, Цагааннуур тосгонд 62,5 хувьтай байгаа нь харилцан адилгүй байна.

Аймгийн дүнгээр зээлийн эргэн төлөлт 20,2 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.


2.2 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй байна.

2.2.1. Сумууд төсөл шалгаруулахдаа журмын заалтыг баримталж ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангаас өмнөх жилүүдэд олгосон 2017 оны эхэнд байгаа үлдэгдэл зээлийн гэрээнүүдийг судалж үзэхэд Алтанцөгц, Баяннуур, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум, Цагааннуур тосгон 251 төсөлд нийт 892.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг барьцаа хөрөнгөгүй олгосон байна.

Алтанцөгц, Баяннуур, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл сумд 255 төслийн 779.9 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Дэлүүн, Өлгий, Алтай, Бугат, Сагсай сумууд зориулалт бус ашиглаж буй талаар хариуцсан мэргэжилтнүүд холбогдох судалгаа хийгээгүй, Булган сум судалгаагаар 26 төсөлд авсан зээлийг зориулалт бус ашигласан байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 19.3 хувь нь зориулалт бусаар ашиглагдаж байхад хяналт тавьж ажиллаагүй, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээ аваагүй, зээлийг хяналтгүй олгосон нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан байна.



Сумууд анх зээл олгохдоо журмын 4 дэх хэсгийн 4.2-д “Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна”, 4.2.3-д “зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх”, 4.3-д “Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл дараах шалгуурыг хангасан байна”, 4.3.3-д “гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх”, 4.3.4-д “төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх”, 4.3.5-д “төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх” гэсэн заалтуудыг хангаж байгаа эсэхийг бүрэн судлаагүй олгосон байна.

Сумууд сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагтаа жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, тэргүүлэх чиглэлээ оновчтой тодорхойлж чадаагүй, сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангаагүйгээс үр өгөөж өгөх төслүүдийг сонгон шалгаруулж чадаагүй байна.

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолох чадвар муу, иргэдийн төлбөрийн чадварыг нарийвчлан тодорхойлоогүйгээс банкны зээлтэй иргэдэд зээл олгосон, сумын Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн зээл олгохоос өмнө объект дээр нь очиж зээлийн судалгаа хийгээгүй байна.

2017 онд 7 сум 76 төсөл шалгаруулж, 319.6 сая төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт №7				/сая төгрөг/			
№	Сумын нэр	Зээлийн 2017.01.01-ний үлдэгдэл		2017 онд зээл, зээлийн хүүгээс эргэн төлүүлсэн дүн	Эргэн төлөлтийн эхний үлдэгдэлд эзлэх хувь	2017 онд шалгаруулсан төсөл	
		тоо	дүн			тоо	Олгосон зээлийн дүн
1	Алтай	61	223.0	83.8	37.6	37	92.5
2	Алтанцөгц	53	219.5	36.2	16.5	4	30.0
3	Баяннуур	96	280.8	62.0	22.1	8	57.6
4	Бугат	36	180.0	18.9	10.5	8	18.0
5	Булган	113	184.6	37.2	20.2	-	-
6	Буянт	42	223.4	99.8	44.7	-	33.0
7	Дэлүүн	69	278.4	49.8	17.9	9	34.0
8	Ногооннуур	62	265.2	8.0	3.0	-	-
9	Сагсай	1	297.1	17.3	5.8	1	3.5
10	Толбо	47	238.3	13.5	5.7	-	-
11	Улаанхус	95	336.6	60.6	18.0	9	51.0
12	Цэнгэл	102	336.3	78.5	23.3	-	-
13	Өлгий	335	961.1	24.7	2.6	-	-
14	Цагааннуур тосгон	4	4.0	2.5	62.5	-	-
Нийт дүн		1116	4028.3	592.8	20.7	76	319.6

Эх сурвалж: Сумуудын СХСангийн зээлийн талаарх нэгдсэн судалгаа

Журмын 1.11-д “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэсэн заалтыг Алтай, Баяннуур, Буянт сум баримталж зээл, зээлийн хүүгийн орлогын 22,1-44,7 хувийг бүрдүүлсний дараа төсөл шалгаруулж зээл олгосон байна.

Алтанцөгц, Бугат, Дэлүүн, Сагсай, Улаанхус сумууд зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр журамд заасан хэмжээнд хүрээгүй байхад 27 төсөл шалгаруулж, нийт 106.7 сая төгрөгийн зээл олгож журмын 11.1 дэх заалтыг зөрчиж ажилласан байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн талаарх саналаа орон тооны бус Зөвлөлд хүргүүлж, Зөвлөл

нь журмын 4.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянаж шийдвэр гаргахаар журамд тодорхой заасан байна.

2.2.2. Өлгий сумын 2011-2016 онуудад 83 иргэн, хуулийн этгээдэд олгосон 424,5 сая төгрөгийн зээлийн гэрээ байхгүй байна.

Тайлант онд журмын 4.5-д “Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн сумын Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана” гэж заасны дагуу 8 сум 76 төсөлд 319.6 сая төгрөгийн зээл олгож, гэрээ байгуулсан байна.

-Баяннуур сумын ИТХ-аас гаргасан “нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг иргэнд 10,0 сая төгрөг байна” гэсэн шийдвэрийг зөрчиж, Засаг даргын 2017 оны 6-р сарын 13-ны өдрийн 52 дугаар захирамжаар Засаг дарга, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн нар иргэн Б.Аманбект 15,0 сая төгрөгийн зээлийг сонгон шалгаруулсан төсөлгүй, барьцаа хөрөнгөгүйгээр шууд гэрээ хийж, хууль бусаар олгосныг тогтоож нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

-Буянт сумын Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамжаар 15 төсөлд 88.0 сая төгрөгийн, А/77 дугаар захирамжаар 2 төсөлд 8.0 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гаргаж, тухайн онд санхүүжилтийн эх үүсвэр хүрээгүйгээс 32.9 сая төгрөгийг 2017 онд олгосон боловч 10 зээлдэгчийн зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулаагүй үлдээсэн байна.

Энэ нь журмын 4.6-д “Сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулна. Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн дансанд шилжүүлнэ” гэж заалттай нийцээгүй байна.

2017 оноос өмнөх онуудад Алтанцөгц сум 50, Баяннуур сум 20, Буянт сум 34, Ногооннуур сум 51, Толбо сум 34, Улаанхус сум 4, Цэнгэл сум 31, Өлгий сум 24, Цагааннуур тосгон 3, нийт 251 төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдэд 892.5 сая төгрөгийн зээлийг барьцаа хөрөнгөгүй олгож, гэрээ хийсэн нь журмын 4.8.7-д “барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг эх хувиар хавсаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2016 оны жилийн эцсийн зээлийн үлдэгдлийг зээлийн гэрээтэй тулгалт хийж үзэхэд 2011-2016 онуудад олгосон Ногооннуур сумын 11, Өлгий сумын 83, бүгд 94 иргэн, хуулийн этгээдэд 519,5 сая төгрөгийн зээл олгосон зээлийн гэрээ байхгүй байна.

Сум хөгжүүлэх сан нь аймгийн Хөдөлмөрийн хэлтэст харьяалагдаж байсан бөгөөд 2016 онд тус хэлтэс бүтцийн өөрчлөлтөөр татан буугдаж, сумуудыг хариуцаж ажиллаж байсан мэргэжилтэн ажлаас гарахдаа дээрх зээлийн гэрээнүүдийг хүлээлгэж өгөөгүй гэсэн тайлбарыг өгсөн байна. Тухайлбал:

Ногооннуур сумын ЖДҮ-ийг хариуцсан мэргэжилтэн К.Уазира нь 2016 оны 12 дугаар сард уг ажлыг мэргэжилтэн А.Көксегенээс хүлээж авахдаа 11 зээлдэгчийн 11 гэрээ, барьцаалах хөрөнгийн материалыг дутуу хүлээж авсан талаар тухайн үеийн ажил хүлээлцсэн хурлын тэмдэглэлд тусгасан талаар тайлбар ирүүлсэн байна.

2016 онд Өлгий сумын 8 иргэн, хуулийн этгээдэд гэрээ байгуулахгүйгээр 52,3 сая төгрөгийн зээл олгосон байна.

2.2.3. 2017 онд хэрэгжүүлсэн төслийн үр дүнд бий болсон ажлын байрыг баталгаажуулаагүй байна.

Төслийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулах, хэрэгжүүлэхгүй байх, дутуу гүйцэтгэх зэрэг зөрчил дутагдлууд байгаа ч зарим иргэн, аж ахуйн нэгжүүд авсан зээлийг зориулалтын дагуу ашиглаж, орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд байна.

2017 онд зээл олгосон 76 төсөл хэрэгжсэнээр Алтай сумд 18, Алтанцөгц сумд 4, Баяннуур сумд 6, Бугат сумд 8, Дэлүүн сумд 13, Сагсай сумд 1, бүгд 50 ажлын байр бий болсон нь ХХҮГазраас гарсан судалгаагаар гарсан боловч ажил олгогчоос төлсөн НДШимтгэл төлөгдсөн баримтыг баталгаажуулаагүй байна. Үүнээс үзэхэд төслийн үр дүнд ажлын байр бодиттой нэмэгдсэн эсэхийг баталгаажуулах боломжгүй байна.



Улаанхус сумын иргэн Т.Али СХСангаас “компьютерийн үйлчилгээ” төслөөр 5.0 сая төгрөгийн зээл авч төслөө амжилттай хэрэгжүүлж ажилласан байна.



Улаанхус сумын иргэн Д.Азамат “Хөх тоосго” төлөөр 3.0 сая төгрөгийн зээл авч 3 ажлын байр, Баяннуур сумын иргэн О.Нурхиса “НурТасБерд”

үйлчилгээний өргөтгөлд 3.0 сая төгрөгийн зээл авч 6 ажлын байр бий болгожээ.



Буянт сумын “Жолжахсы” хоршоо 2014 онд 20.0 сая төгрөгийн зээлийг “Эсгийний үйлдвэр” төслөөр авч 9 хүний ажлын байр бий болгосон.



Буянт сумын иргэн О.Эрдэнэ-чулуун 8.0 сая төгрөгийн зээлийг “Сүү, цагаан идээ” төслөөр авч 3 хүний ажлын байр бий болгожээ.

Журмын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна” гэж заасан.

Сумууд 2017 онд зээлийн хүүгээс нийт 8,1 сая төгрөг төвлөрүүлсэнээс 7.9 сая төгрөгийг дээрхи зориулалтаар зарцуулсан байна.

Хүснэгт №8

/сая төгрөг/

№	Сумын нэр	Тухайн жилийн зээлийн хүүгийн орлого	Хяналт тавих үйл ажиллагаанд		Зөрүү
			Зарцуулах ёстой мөнгөн дүн	Зарцуулсан мөнгөн дүн	
1	Алтай	2.7	0.5	0.5	0.0
2	Алтанцөгц	4.4	0.9	0.9	0.0
3	Баяннуур	7.9	1.6	0	1.6
4	Бугат	0.1	0.0	0.4	(0.4)
5	Булган	3.7	0.7	0.5	0.2

6	Буянт	6.4	1.3	0.7	0.6
7	Дэлүүн	4.9	1.0	1.4	(0.4)
8	Ногооннуур	1.6	0.3	-	0.3
9	Сагсай	1.8	0.4	0.5	(0.1)
10	Толбо	0.2	0.0	-	0.0
11	Улаанхус	4.3	0.9	0.3	0.6
12	Цэнгэл	1.1	0.2	0.4	(0.2)
13	Өлгий	1.2	0.2	-	0.2
14	Цагааннуур тосгон	0.3	0.1	-	0.1
	Нийт дүн	40.6	8.1	5,6	

Эх сурвалж: Сумуудын СХСангийн зээлийн талаарх нэгдсэн судалгаа

Бугат, Дэлүүн сум журмын 1.8-д зааснаас 0,1-0,4 сая төгрөгөөр илүү зарцуулжээ. Энэ нь тухайн сумуудын сан хариуцсан мэргэжилтнүүд эргэн төлөлтийн бүртгэл, тооцоог зохих журмаар хөтлөөгүй байгаатай холбоотой.

Журмын 1.9-д “Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг аймгийн хэмжээнд мөрдөж ажиллажээ. Аудитаар:

-Баяннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн 2016 оны хүүгийн орлогоос 202,0 мянган төгрөгийг “Хөх хөтөл” давааны зам засах ажлын шатахуун, тээврийн хөлсөнд зориулалтын бус зарцуулсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

-Тус сумын иргэн Ж.Ахмаралд “Шинэ саам ба айраг” төслөөр олгосон 10,0 сая төгрөгийн болон иргэн Ж.Унатад газар тариалан, мод тарих зориулалтаар олгосон 5,0 сая төгрөгийн төслийн хэрэгжилтийг аудитын явцад газар дээр нь шалгаж үзэхэд төслийн дагуу хийж хэрэгжүүлсэн тодорхой ажил байхгүй, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байгаа нь тогтоогдож, холбогдох этгээдүүдээр нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Аудитаар Сум хөгжүүлэх сангаас олгосон төлөгдөх хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдлийг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах, төлөгдөх найдваргүй болсон зээл, хүүгийн төлбөрийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлэх, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг зөрчиж барьцаа хөрөнгөгүй зээл олгосон зөрчлүүдийг бүрэн арилгаж, цаашид журам зөрчиж зээл олгох явдлыг таслан зогсоох, журмыг зөрчсөн албан тушаалтнуудад тухай бүр хариуцлага тооцож ажиллах талаар сумын Засаг дарга нарт албан шаардлага өгөгдлөө.

2.3. Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.1. Сумын ИТХурал, Засаг дарга нар журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Журмын 3.3-д заасны дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоож, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавьж, орон тооны бус Зөвлөлийг байгуулж ажиллах үүрэгтэй.

Бугат, Дэлүүн сумууд зээлийн дээд хэмжээг тогтоогоогүй байхад 52.0 сая төгрөгийн зээл олгож журмын 3.3.1-д заасныг мөрдөж ажиллаагүй байна. Бусад 6 сум дээрх заалтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Журмын 3.3.3-д төсөл шалгаруулахдаа тухайн сумын Засаг даргаар ахлуулсан, ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулсан орон тооны бус Зөвлөлийг байгуулж ажиллах талаар заалтыг сумууд мөрдөж ажилласан боловч Баяннуур, Бугат, Улаанхус, Сагсай сумууд "... баг тус бүрээс нэг нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулах" гэснийг баримтлаагүй байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн сонгох талаар журмын 3.4.1-д заасныг сумууд хэрэгжүүлээгүй байна.

Журмын 3.5-д заасны дагуу сумын Засаг дарга сонгон шалгаруулах үйл ажиллагаанд сумын иргэдийн оролцоог хангах, зээл олгох иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, үр дүнд хяналт тавьж, зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажилласан талаар сумын ИТХ тайлагнах үүрэгтэй.

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст 3001,0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй, 251 төсөлд 892.5 сая төгрөгийн зээлийг барьцаа хөрөнгөгүй, 19 төсөлд 147.3 сая төгрөгийн зээлийг гэрээ байгуулаагүй олгосон нь сумын Засаг дарга нар журамд заасан үүргээ хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.

Сумын ИТХ, Засаг даргын үүргийн биелэлт хангалтгүй, орон тооны бус зөвлөл зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй, зээл төлүүлэх талаар шаардлага тавьж ажиллаагүй байгаа нь Сум хөгжүүлэх сангийн зээл хугацаа хэтэрч, үр өгөөж нь буурахад нөлөөлсөн байна.

Журмын 5.3.3-д орон тооны бус зөвлөл нь аймгийн ЗДТГазрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжийн хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг сумын нийт иргэдэд мэдээлж, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ болон ЖДҮ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлж байх талаар заасан боловч сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ихэнх сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй, үр дүнг иргэдэд мэдээлээгүй байна.

Журмын 5.2-д "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана" гэсэн заалтын дагуу сумын Засаг дарга нарт Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөдлөө.

Орон тооны бус хяналтын Зөвлөл журмын дагуу ажиллаагүй, хяналт шалгалт хийсэн тайлан байхгүй, хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, зээлийн үр дүн буурах, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл өсөх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнест эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна. Иймд СХС-ийн үйл ажиллагаанд орон нутгийн болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтнууд хууль журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Тус журмын 5.2-д сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах талаар заасны дагуу сумын Засаг дарга нарт зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага өгөв.

2.3.2 Сумууд сангийн жилийн эцсийн зээлийн үлдэгдлийг баталгаажуулаагүй ирсэн байна.

Журмын 1.5-д “Сум бүр сангийн орлого зарлагын гүйцэтгэлийн тайланг тухайн сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайланд тусгана” гэсэн заалтын дагуу Сум хөгжүүлэх сангийн тайлант оны орлого, зарлага, дансны болон зээлийн авлагын үлдэгдлийг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж ажилласан байна.

Сумууд Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг тусдаа гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүнд оруулж тайлагнасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Сум хөгжүүлэх сангийн нийт 303.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 3954.4 сая төгрөгийн зээлийн авлага тусгаж аудиторудын нэгтгэж гаргасан зээлийн үлдэгдэлээс 26,3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь зээлийн хүүгийн тооцоолол зөрүүтэй байгаатай холбоотой байна.

Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн сумдаас Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын талаарх мэдээ тайланг файлаар авч нэгтгэж байгаа боловч тухайн мэдээ үнэн зөв эсэхийг анхан шатны баримттай тулган баталгаажуулаагүй байна.

Сумууд жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахаас өмнө сангийн зээлийн үлдэгдлийг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулалт хийгээгүй, сангийн бүртгэл тайланг хагас дутуу хөтөлж, сангийн санхүүгийн тайланг хэлэлцүүлж, баталгаажуулаагүй байна.

Сум бүр сангийн орлого зарлагын гүйцэтгэлийн тайланг тухайн сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайланд тусгана гэж журмын 1.5-д заасан дагуу сар бүрийн төсвийн гүйцэтгэлд сангийн орлого зарлагыг тусгахгүй байгаа нь дээрх заалтыг зөрчиж байна. Харин хагас, бүтэн жилийн тайланг гаргаж аймгийн СТСХэлтэст хүргүүлж ажилласан байна.

Мөн аймгийн ХХААГ нь сумдын сум хөгжүүлэх сангийн улирлын мэдээг авч нэгтгэн дараа улирлын эхний сарын 10-нд тогтмол ХХААХҮЯамд хүргүүлж ажилласан байна.

Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэнд сумдаас СХС-ийн зарцуулалтын талаарх мэдээ тайланг файлаар ирүүлж байгаа нь шаардлага хангахгүй, тухайн мэдээ үнэн зөв эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, зээлийн бүртгэл тооцоо нь зөрүүтэй, СХС-ийн зарцуулалтын тайлан цаг хугацаа хоцрох, хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцох боломж хязгаарлагдмал байна. Мөн аудитын явцад сумуудын СХСангийн зарцуулалт, үлдэгдлийн баталгаажуулалтад хийсэн тооцоог аймгийн ХХАА-н газрын СХС-г хариуцсан мэргэжилтнээс ирүүлсэн тооцоотой зөрүүтэй гарч байгаа нь ажиглагдсан.

Иймд цаашид ХХААГ-ын СХС-г хариуцсан мэргэжилтэн нь СХС-ийн хөрөнгийн зарцуулалтын тайланг сумдаас албан ёсны, нотлох баримтаар баталгаажуулан хугацаанд нь гаргуулан баталгаажуулж ажиллах шаардлагатай байна.

2.3.3. Зээлийг хугацаандаа төлөөгүй, төслийг зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжийг шүүхэд шилжүүлж байгаа боловч үр дүн муутай байна.

Сум хөгжүүлэх санд 2017 оны эцэст хугацаа хэтэрсэн нийт 3001.0 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт№ 9		/сая төгрөг/					
№	Сумын нэр	Хугацаа хэтэрсэн зээлийн		Шүүхэд шилжүүлсэн зээлийн		Зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоогоор	мөнгөн дүнгээр
1	Алтай	98	134.7	61	130.7	62.2	97.0
2	Алтанцөгц	57	161.0	29	70.2	50.9	43.6
3	Баяннуур	104	253.4	31	59.1	29.8	23.3
4	Бугат	36	125.9	35	92.8	97.2	73.7
5	Булган	86	127.8	23	59.0	26.7	46.2
6	Буянт	14	31.9	6	13.6	42.9	42.6
7	Дэлүүн	57	124.4	13	80.0	22.8	64.3
8	Ногооннуур	59	229.2	15	41.5	25.4	18.1
9	Сагсай	29	147.7	29	147.7	100.0	100.0
10	Толбо	31	158.2	19	109.6	61.3	69.3
11	Улаанхус	104	338.1	22	138.8	21.2	41.1
12	Цэнгэл	98	258.4	22	89.6	22.4	34.7
13	Өлгий	243	908.8	-	-	0.0	0.0
14	Цагааннуур тосгон	3	1.5	-	-	0.0	0.0
	Дүн	1019	3,001.0	305	1,032.6	29.9	34.4

Эх сурвалж: Сумуудын СХСангийн зээлийн талаарх нээгдсэн судалгаа

Өмнөх жилүүдэд Өлгий сумаас бусад бүх сум 305 иргэн, хуулийн этгээдийн хугацаа хэтэрсэн 1032.6 сая төгрөгийн зээлийг шүүхэд шилжүүлж эвлэрлийн гэрээ, шүүхийн захирамж гаргуулан ажиллаж байгаа боловч тодорхой үр дүн гараагүй, зээлийн хугацаа хэтрэлт арилаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн нийт зээлийн үлдэгдлийн 30,3 хувь нь Өлгий сумын Сум хөгжүүлэх санд ногдож байгаа боловч хугацаа хэтэрсэн 908,8 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Цаашид зээлийг эргэн төлөх чадвартай, үр өгөөжтэй төслийг санхүүжүүлэх, журам зөрчиж чанаргүй зээл олгосон, хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Аудитын явцад Нийцлийн аудитын газраас ирүүлсэн санал асуулгын хуудсаар 12 сумын 158 иргэнээс Сум хөгжүүлэх сангийн талаар санал асуулга авлаа. Санал асуулгад үйлдвэрлэлийн чиглэлээр 37, үйлчилгээний чиглэлээр 65, худалдааны чиглэлээр 56 зээл авсан иргэн хамрагдлаа.

Сум хөгжүүлэх сангийн талаар 112 иргэн хангалттай, 46 иргэн хангалтгүй мэдээлэлтэй байна гэсэн бол 72 иргэн сумын Засаг дарга нараас, 29 иргэн орон

нутгийн мэдээллийн самбар, радио, телевизээс, 8 иргэн иргэний танхимаас, 49 иргэн нутгийн иргэдээс мэдээлэл авч байна гэж хариулжээ.

106 иргэн сум хөгжүүлэх сангийн талаарх журам зааврыг судалж үзсэн, 52 иргэн судлаагүй гэсэн хариу өгчээ. Үүнээс үзэхэд орон нутгийн зээлдэгч нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт явуулаагүй байгаа нь харагдаж байна.

Санал асуулгад оролцсон иргэдийн 99 нь уг сангаас зээл авч байсан бол 59 нь зээл аваагүй иргэн байна. Сангийн зээлийн үйл ажиллагаанд 96 иргэн хангалттай сайн, 42 иргэн хангалтгүй, 20 иргэн мэдэхгүй байна гэж хариу өгчээ.

Судалгаанд хамрагдсан иргэд сангийн үйл ажиллагаанд 60.7 гэсэн үнэлгээ тавьж байгаа нь бизнес эрхлэгч иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгааг харуулж байна. Үр ашгийн талаарх асуултад ажлын байр нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгч байгаа боловч бага хэмжээний зээл авахад эргэлтэд оруулж чадахгүй, үр өгөөж бага байгаа талаар бичжээ.

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар нийтдээ 3108,4 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 30.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3078,2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

ОНХСан, СХСангийн зарцуулалтад хийсэн аудитын дүнгээр материаллаг хэмжээний зөрчил гаргасан Өлгий, Баяннуур, Булган сумын Засаг дарга нарт хариуцлага тооцуулах санал хүргүүлэв.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой 2 заалт бүхий зөвлөмж өгсөн болно.

2.4. Сангийн хөрөнгийг банкаар дамжиж олгохгүй байгаа нь зээлийн хүүгийн бодолт, зээлийн эргэн төлөлтийн хяналт хангалтгүй хэрэгжиж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Сум хөгжүүлэх сангаас 2011-2017 онд олгосон зээлийн үр дүнгээс харвал зээлийг олон хүнд хүртээмжтэй байдлаар хэт жижиглэнгээр олгох, сангийн 20 хувь бүрдээгүй байхад зээл олгох, төсөл сонгон шалгаруулалт ил тод бус, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд иргэдийн төлөөлөл бус сумын иргэдийн төлөөлөгчийг оруулдаг, хяналт тавих эрх бүхий орон тооны зөвлөл жил бүр хяналт тавьж ажилладаггүй, баримт бичгийн бүрдэл дутуу, барьцаа хөрөнгө хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах зэрэг нийтлэг зөрчлүүд илэрч байна.

Иймд сангийн үйл ажиллагааг улс төрөөс ангид байлгаж, төрийн захиргааны албан хаагчаар төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг удирдуулах, ил тод, ашиг сонирголоос ангид байлгах, үр өгөөжтэй, ажлын байр бий болгох төсөлд санхүүжилт олгох талаар журамд тодорхой тусгаж, шат шатанд тавигдах хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Сангийн хөрөнгийг банкаар дамжиж олгохгүй байгаа нь зээлийн хүүгийн бодолт, зээлийн эргэн төлөлтийн хяналт хангалтгүй хэрэгжиж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Бүлэг 2. Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2.1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

2.1.1. Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаагаас сангийн орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй байна.

2.1.2. Сангаас олгосон зээлийг хугацаанд эргэн төлүүлэх талаар хангалтгүй ажилласнаас нийт зээлийн үлдэгдлийн 74,5 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

2.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй байна.

2.2.1. Сумууд төсөл шалгаруулахдаа журмын заалтыг баримталж ажиллаагүй байна.

2.2.2. Өлгий сумын 2011-2016 онуудад 83 иргэн, хуулийн этгээдэд олгосон 424,5 сая төгрөгийн зээлийн гэрээ байхгүй байна.

2.3. Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.1. Сумын ИТХурал, Засаг дарга нар журамд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2.3.2 Сумууд сангийн жилийн эцсийн зээлийн үлдэгдлийг баталгаажуулаагүй ирсэн байна.

2.3.3. Зээлийг хугацаандаа төлөөгүй, төслийг зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгжийг шүүхэд шилжүүлж байгаа боловч үр дүн муутай байна.

2.4. Сангийн хөрөнгийг банкаар дамжуулан олгохгүй байгаа нь зээлийн хүүгийн бодолт, зээлийн эргэн төлөлтийн хяналт хангалтгүй хэрэгжиж сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Нургулан-д:

1. Засгийн газрын 2016 онд 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллан, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах талаар сумын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнийг удирдлага арга зүйгээр хангах, тодорхой арга хэмжээ авч ажиллах

2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, үр дүнг тооцож ажиллах талаар арга хэмжээ авч ажиллах;

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

Гурав. Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

3.1. Өмнөх онд ОНХСангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргад ОНХСангийн хөрөнгөөс зориулалт бус төсөл, арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан, иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн байдалд дүгнэлт хийж, цаашид энэхүү зөрчлийг арилгуулах, ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгсөн байна.

Энэ удаагийн аудитаар аймгийн ОНХСангийн хөрөнгөөс иргэдийн саналыг аваагүй төсөл арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн зөрчил давтагдан гарч өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 61,0 хувьтай хэрэгжсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар аймаг, сумын ОНХСанд нийт 505,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлж, тухайн байгууллагууд биелэлтийг хугацаанд ирүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлтийг аудитын явцад давтан шалгаж үзэхэд Булган сум албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Ногооннуур сум, Цагааннуур тосгоны албан шаардлагын биелэлт 24,9-33,0 хувьтай ба нийт дүнгээр 61,0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11 /сая төгрөг/

№	Сумын нэр	Албан шаардлага		
		Дүн	биелэлт	хувь
1	Алтанцөгц	8.0	8.0	100.0
2	Булган	127.8	-	-
3	Дэлүүн	20.7	20.7	100.0
4	Ногооннуур	74.3	24.5	33.0
5	Сагсай	7.7	7.7	100.0
6	Улаанхус	22.8	22.8	100.0
7	Цэнгэл	30.0	30.0	100.0
8	Цагааннуур	26.1	6.5	24.9
9	Аймаг	187.9	187.9	100.0

	нийт дүн	505.3	308.1	61.0
--	-----------------	--------------	--------------	-------------

Эх сурвалж: Өмнөх оны ОНХСангийн албан шаардлагын биелэлтийн судалгаа

ОНХСангийн 2014-2017 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр нэгтгэж үзэхэд нийдээ 6004,5 сая төгрөгийн зөрчил илэрч 45,2 сая төгрөгийн акт тогтоож, 5959,30 сая төгрөгийн албан шаардлага, 81 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна. Холбогдох байгууллагууд аудитын дүнгээр зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, дүнг тайлагнасан байна.

Хүснэгт №12

/сая төгрөг/

Он	Илэрсэн зөрчлийн дүн	Тогтоогдсон		Зөвлөмж
		Акт	Албан шаардлага	
2014 он	315.3	3.3	71.4	5
2015 он	4749.7	39.2	4710.5	66
2016 он	434.2	2.7	431.5	6
2017 он	505.3		505.3	4
Дүн	6004,5	45,2	5959,3	81

Эх сурвалж: Өмнөх оны ОНХСангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Өмнөх оноос зориулалт бус зарцуулсан зөрчил буурсан бол иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн, бүртгэл тайланд тусгаагүй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй, төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй, хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй, захиалагчийн хяналт тавиагүй зөрчлүүд нэмэгдсэн байна.

Энэ нь орон нутгийн удирдлагууд холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөөгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байгаатай холбоотой байна.

ОНХСангийн зарцуулалтад хийсэн аудитаар нийтдээ 1298,7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 81,8 хувь буюу 1075,4 сая төгрөг нь Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн алдаа зөрчил эзэлж байна.

3.2. Өмнөх онд Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, нийцлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.


3.1. Өмнөх онд ОНХСангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.1.Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1.2.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 61,0 хувьтай хэрэгжсэн байна.

Холбогдох байгууллагын санал

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн санал:



Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар.

1.ХХААГ-аас СХСангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байсан талаар холбогдох нотлох баримтыг аудитын явцад ирүүлээгүй тул аудитын тайланд оруулах боломжгүй байна.

2. Сум хөгжүүлэх сангийн журам зөрчсөн асуудлыг тайланд тусгаж, Сумын Засаг дарга нарт зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн болно. Сум хөгжүүлэх сангийн журам зөрчиж ажилласан сумын удирдлагуудад хариуцлага тооцуулах талаар аймгийн Засаг даргад хандаж байсан талаар аудитын явцад холбогдох нотлох баримт ирүүлээгүй болно.


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/33

Өгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын хоёрын 2.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, 2016 оны А/95 тушаалаар баталсан "Акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын хавсралтын долоо дахь хэсгийн 7.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ

1. Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчилд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын мөрөөр тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ербол, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Болат, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Нургулан нарт зөвлөсүгэй.

5. Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Х.Манаргүлд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Х.Женисбект тус тус даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М ХУАНГАН

D:\bichig hereg\2018\tushaal.doc

ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М. ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Х.МАНАРГҮЛ
М.АЙНУР

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА
Ж.НАЗГҮЛ
Х.ЕРКЕБУЛАН